



БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Банкны салбарын нийт активын хэмжээ 2011 оны хоёрдугаар улирлын эцсийн байдлаар 7.5 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 0.9 их наяд төгрөгөөр буюу 13.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.6 их наяд төгрөгөөр буюу 53.0 хувиар өслөө. Харилцах, хадгаламжийн өсөлтөөс хамааран зээлийн хэмжээ нэмэгдсээр байна. Хоёрдугаар улирлын эцсийн байдлаар нийт зээлийн хэмжээ 4.4 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 0.8 их наяд төгрөгөөр буюу 22.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөгөөр буюу 49.9 хувиар нэмэгдлээ. Нийт зээлийн багцын 93.5 хувийг хэвийн, 1.7 хувийг хугацаа хэтэрсэн, 4.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Банкны системийн хэмжээгээр 212.3 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байгаа нь өмнөх улирлаас 1.7 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар өссөн хэдий ч чанаргүй зээлийн харьцаа 1 нэгжээр буурч 4.9 хувьд хүрээд байна. Банкуудын төгрөгийн зээлийн хүү 2011 оны хоёрдугаар улирлын эцсийн байдлаар 16.2 хувьд хүрсэн нь оны эхнээс 2.2 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгжээр буурсан бол валютын зээлийн хүүгийн хэмжээ оны эхнээс 0.2 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгжээр буурч байгаа нь зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Хөрвөх чадвар бүхий активын хэмжээ 2.7 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 155.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Хөрвөх активын хэмжээ нэмэгдэж байгаа ч эх үүсвэрийг зээлд түлхүү байршуулж байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 5.1 нэгжээр буурч 40.1 болоход нөлөөллөө. Мөнгөн хөрөнгийн хэмжээ тайлант улиралд 1.6 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 34.1 тэрбум төгрөгөөр, богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 1.2 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 121.8 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ.

Харилцах 2.1 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 455.9 тэрбум төгрөгөөр буюу 28.1 хувиар, хадгаламж 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 368.4 тэрбум төгрөгөөр буюу 11.6 хувиар өсчээ. Хадгаламжийн өсөлтийн дийлэнх хэсгийг иргэдийн болон бусад төрлийн хугацаатай хадгаламж бүрдүүлж байгаа нь эх үүсвэрийн дундаж хугацаа нэмэгдэж зээл олгох нөхцөл бүрдэх боломжтой байна. Эх үүсвэрийн жигнэсэн дундаж хүүгийн хэмжээ буурсаар байгаа хэдий ч харилцах, хадгаламжийн хэмжээ нэмэгдсээр байгаа нь харилцагчдын банкинд итгэх итгэл тогтвортой байгаа, эдийн засаг дахь хөрөнгийн орох урсгалын өсөлт нэмэгдсээр байгаа зэргээс шалтгаалж байна.

МОНГОЛБАНКНААС БИЧИЖ БАЙНА...

Банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2011 оны 2 дугаар улирлын байдлаар 760.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 108.1 тэрбум төгрөгөөр буюу 16.6 хувиар өслөө.

МОНГОЛБАНК